

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Булган Мээж ХХК-ий 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2020/З/СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2019 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын захирал
бөгөөд

тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70352580 Цахим хаяг: bulgan@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: bulgan@audit.gov.mn

Аудитор: Д.Мягмарсүрэн

Утас: 70353717 Цахим хаяг: dalaivanaudit.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	10
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14

2.1. Оршил

Булган Мээж ХХК-ий 2019 оны санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Булган Мээж ХХК-ий захирал Д.Очирбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган Мээж ХХК-ий 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Булган Мээж ХХК-ий 2019 оны санхүүгийн тайланд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Булган Мээж ХХК нь санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 01-нээс 2020 оны 03 дугаар сарын 06-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Далайван аудит ХХК орхон салбарын аудитор Б.Пүрэвсүрэн /Булган аймгийн төрийн аудитын газрын захиалгаар/ хариуцаж хэрэгжүүлэв.

Булган Мээж ХХК-ий 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Далайван аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 01/24 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Булган Мээж ХХК-ий 2019 оны үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Иргэд байгууллагын эрх ашгийг эрхэмлэн хүндэлж, эрүүл ахуйн стандарт хангасан цэвэр ус түгээн нийлүүлж, хэрэглэгчдийг найдвартай дулааны эрчим хүчээр хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулан ажиллахад” оршино.

Булган Мээж ХХК-ий үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.
Үүнд:

- Дулаан ус хангамж

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журам.
Үүнд:

- Компаний тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль
- Ахмадийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Булган Мээж ХХК-ий мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Булган Мээж ХХК-ий санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Винеица программ хангамж ашигладаг байна.

Булган Мээж ХХК-ий албаны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Булган Мээж ХХК-ий бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 7 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2,346,042.6 мянган төгрөгөөс тооцон 46,920.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Булган Мээж ХХК-ий 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 422,433.6 мянган төгрөгөөр буюу 5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	839,229.5	590,211.8	-249,017.7
Авлага	156,286.4	156,283.9	-2.5
Урьдчилгаа			
Бараа материал	360,211.7	334,720.6	25,491.1
Үндсэн хөрөнгө	6,120,039.0	6,837,347.6	717,308.6
Нийт хөрөнгө	7,539,630.5	7,962,064.1	422,433.6
Өр төлбөр	3,579,895.4	3,584,517.1	4,621.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,959,735.0	4,377,546.9	417,811.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,539,630.5	7,962,064.1	422,433.6

Тус компани нь 2019 онд 653.4 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж өмнөх оноос алдагдал 696.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Алдагдал нэмэгдсэн шалтгаан нь шинээр Дулааны цахилгаан станц ашиглалтанд орсонтой холбоотой хөрөнгийн элэгдэл 247.0, өвлийн улиралд халаалт доголдсонтой холбоотой 2 уурын зуух нэмж ажиллуулсан зардал 78.9, хүн амыг ундны усаар хангах зөөврийн усны алдагдал 233.9, хувийн орон сууцны "Нида" уурын зуухыг компанид хариуцуулсны зардал 45.2, шинээр ашиглалтанд орсон "Хан жаргалант" худалдааны төвийн халаалтын алдагдал 2.5, нийтийн шугам хоолойн болон бусад шаардлагатай засварын зардал 69.3 нийт 676.8 сая төгрөгийн зардал гарсан, мөн дулааны станц ашиглалтанд орж уурын зуухнуудыг хаасан ч компаний бүтэц, орон тоог өөрчлөөгүй хэвээр ажилласан зэрэг нь алдагдалтай ажиллахад нөлөөлсөн байна. Иймд цаашид хүн амын ундны усаар хангах зөөврийн усны алдагдлыг төрөөс нөхөж авах, "Хан жаргалант" худалдааны төвийн алдагдлын тооцоог гаргаж шийдвэрлэх, компаний бүтэц, орон тоог оновчтой хэлбэрээр шинэчилж алдагдлыг буурлуулах зохион байгуулалттай арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Дулааны цахилгаан станц ажилласнаар Булган Мээж ХХК-ийн 3 том уурын зуух зогссоноор ихэнх хөрөнгө ашиглагдахгүй зогссон ч үндсэн бүтэц орон тоогоороо ажиллаж байгаа цалингийн зардал, үнэ тариф, элэгдлийн зардал зэрэг нь уг алдагдалд ихээхэн нөлөөлж байна. Тайлангийн хугацаанд ажиллагаагүй уурын зуухнуудын ашиглагдахгүй байгаа хөрөнгөнд 147.9 сая төгрөгийн элэгдэл тооцогдож татвар ноогдох орлогоос хасагдсан байна.

Жилийн эцсийн байдлаар 156.2 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй гарсан. Нийт борлуулалтын авлагын 98 хувийг барагдуулсан байна. Аж ахуй нэгж байгууллагаас авах авлага 53.25 сая төгрөгөөр буюу өмнөх оноос 12.6 сая төгрөгөөр, орон сууцны авлага 11.3 сая төгрөг буюу 0.79 мянган төгрөгөөр өссөн, бусад авлага 91.7 сая төгрөгөөр буюу 13.4

сая төгрөгөөр буурсан нийт 2.5 мянган төгрөгөөр буурсан байна. Нийт авлагын 2.8 хувь буюу 4.5 сая төгрөгийн төсөвт байгууллагаас авах авлага, 31.1 хувь буюу 48.7 сая төгрөгийн аж ахуй нэгж байгууллагаас авах авлага, 7.2 хувь буюу 11.3 сая төгрөгийн бусад авлагын үлдэгдэлтэй байна. Бусад авлагын 43.4 сая төгрөг нь ДДТ-3-т хийсэн өргөтгөлийн мөнгөн 2020 оны аймгийн төсөвт суусан, 8.5 сая төгрөг нь халдвартын эмнэлгийн бохирын засварыг дуусгаж хүлээлгэн өгөх хүртэл банкны баталгаа болгож дансанд байршуулсан байна. Аж ахуй нэгж байгууллагаас авах авлага нь Зулзган түшиг ХХК-ий 4.5 сая төгрөг, Битүү зах 5.5 сая төгрөг, АЗЗА ТӨХК 8.1 сая төгрөг, 1-р халуун ус 12.3 сая төгрөг, Алл март үйл төв 3.0 сая төгрөг, Хангай пресс хэвлэх үйлдвэр 2.6 сая төгрөг, Интеко инженеринг ХХК 2.0 сая төгрөгийн ААН байгууллагаас авах авлагатай гарсан байна. Тайлант онд 5 алын 1.5 сая, 2 аж ахуй нэгж байгууллагын 3.5 сая төгрөг нийт 5.0 сая төгрөгийн хуулийн байгууллагаар шийдвэрлүүлсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 25,491.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 54,249.8 мянган төгрөгийн аж ахуйн материал, 453,956.6 мянган төгрөгийн түлш, 154,306.0 мянган төгрөгийн шатах тослох материал, 78,577.7 мянган төгрөгийн барилгын материал, 10,198.4 мянган төгрөгийн цахилгааны сэлбэг, 160,339.2 мянган төгрөгийн сангийн сэлээг, 37,557.9 мянган төгрөгийн авто сэлбэгийн материал, 11,271.4 мянган төгрөгийн хангамжийн материал, нийт 972,876.6 мянган төгрөгийн бараа материал худалдан бэлтгэсэн байна. Тайлант онд нийт 1,087,622.2 мянган төгрөгийн бараа материал зарцуулан нийт 26,096 тооны 309,329.7 мянган төгрөгийн өртөгтэй бараа материалын үлдэгдэлтэй гарсан байна.

Үндсэн хөрөнгийн данс тайлант онд 717.3 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй гарсан байна. Үүнээс барилга байгууламж 464.3 сая төгрөг, машин тоног төхөөрөмж 768.1 сая төгрөг, авто тээврийн хэрэгсэл 15.6 сая төгрөг, тавилга эд хогшил 18.1 сая төгрөгөөр тус тус орлогод бүртгэсэн байна. Нэмэгдсэн хөрөнгийг ангилалаар нь авч үзхэд барилга байгууламж данс 4.5 сая төгрөгийн авто гражийн барилга, төв усан сангийн хашаа 78.8 сая төгрөг, дулаан дамжуулах төвийн барилга 134.4 сая төгрөг, дулаан дамжуулах төвийн барилга 134.4 сая төгрөг, эмнэлэг дулаан дамжуулах төвийн барилга 134.4 сая төгрөг нийт 486.6 сая төгрөгөөр орлогод бүртгэсэн байна. Машин тоног төхөөрөмжийн данс цахилгаан үүсвэр 2.7 сая төгрөг, хийн компрессор 1.7 сая төгрөг, цахилгаан үүсгэвэр 5 квт 5.9 сая төгрөг, эргэлтийн насос 6.6 сая төгрөг нийт 16.9 сая төгрөгийн хөрөнгө 1 дүгээр агуулхад, усны чайн 5.0 сая төгрөг, ухаалаг ус цэг 2.0 сая төгрөг нийт 7.0 сая төгрөгийн хөрөнгө 3 дугаар агуулхад, 298.5 сая төгрөгийн андууд дэлгүүрээс ГБХЗГ хүртэл дулааны шугам, 369.2 сая төгрөгийн дулааны шугам, 46.1 мянган төгрөгийн МСҮТ 2 дугаар худгаас 5А хүртэл 2 хос дулааны шугам нийт 713.9 сая төгрөгийн хөрөнгө 5 дугаар агуулхад, 12.6 сая төгрөгийн 1-р халуун усны цэвэр усны шугам 7 дугаар агуулхад, 31.6 сая төгрөгийн 1000-ийн яндан 9 дүгээр агуулхад, системийн насос 15 кв 3.5 сая төгрөг, давтамж хувиргагч 1.8 сая төгрөг, системийн насос могод 1.9 сая төгрөг нийт 7.2 сая төгрөгийн хөрөнгө 15 дугаар агуулхад, ус цэвэршүүлэгч 9.4 сая төгрөгийн хөрөнгө 18 дугаар агуулхад, давтамж хувьсгуур 4.1 сая төгрөг, ус цэвэршүүлэгч 9.4 сая төгрөг нийт 13.5 сая төгрөгийн хөрөнгө 19 дүгээр агуулхад, ус цэвэршүүлэгч 9.4 сая төгрөгийн хөрөнгө 20 дугаар агуулхад, яндан 9.5 сая төгрөг 21 дүгээр агуулхад тус тус орлогодож бүртгэлд тусгасан байна. Тээврийн хэрэгсэл дансанд крантай машин, үйлчилгээний жижиг машин, автоцистерн бохирын гэсэн гурван төрлийн 25.6 сая төгрөгийн өртөгтэй тээврийн хэрэгсэл хүлээн авч орлогод бүртгэсэн байна. 19.7 сая төгрөгийн тавилга эд хогшил, 0.2 сая төгрөгийн зохиогчийн эрх нийт 1,363.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө орлогодож бүртгэлд тусгасан байна. Энэ нь Төрийн болон орон нутгын өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдаж авах хуулийн дагуу ИТХ-ын тогтоолоор 127.1 сая төгрөг, байгууллагын ӨХК-ын шийдвэрээр 86.2 сая төгрөг, ОНХ оруулалтаар 1,150.0 сая төгрөг нийт 1,363.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогодож авсан байна. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор 78.8 сая төгрөг, өмч хамгаалах комиссын шийдвэрээр 25.2 сая төгрөг нийт 97.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хассан байна.

Тайлант онд бие бус хөрөнгөд өөрчлөлт буюу өсөлт, бууралт ороогүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга хийгдээгүй.

2.11 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 7 эрсдэл тодорхойлж нийт 14 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 13,002.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 0 мянган төгрөгийн алдааг залруулж, 334.0 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 3,598.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 9,069.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг өглөө.

Аудитаар дараах 13,002.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 334.0 мянган төгрөгийн төлбөр барагдуулах акт, 3,598.5 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Кассаас 202.0 мянган төгрөгийн хувь хүний сугалаатай баримтаар гүйлгээ хийсэн мөн 132.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материалыг анхан шатны баримтгүй худалдан авсан.

Шийдвэрлэсэн нь:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5 зүйл "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна." гэсэн заалтын дагуу баримт бүрдүүлэн гүйлгээг хийхийг сануулж төлбөр барагдуулах актаар хүргүүллээ.

2. Тайлангийн хугацаанд байгууллагын даргын тушаалаар нийт 9 ажиллагсдад сахилгын арга хэмжээ авсан боловч үр дүнгийн урамшуулал 3 598.5 мянган төгрөгийг олгосон байна.

Шийдвэрлэсэн нь:

Хөдөлмөрийн тухай хуулийн 12 дугаар бүлгийн 131 дүгээр зүйлийн 131.4 дэх заалт "Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно" гэсэн заалтын дагуу үр дүнгийн урамшуулал олгохыг албан шаардлагаар хүргүүллээ.

Аудитаар илэрсэн 9,069.8 мянган төгрөгийн 7 алдаа, зөрчилд зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар зөвлөмжийн биелэлтийн хэрэгжилтийг шалгаж үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Булган Мээж ХХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан шилэн данстай холбоотой 60 асуумж мэдээлэл тайлагнах байснаас 58 удаа хугацаандаа бөглөж 2 удаа хоцроосон байна. Байгууллагын шилэн дансны самбарын мэдээллийг тухай бүр шинчлэн ажилладаг байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар Булган аймгийн төрийн аудитын газраас зөрчилгүй санал дүгнэл авсан ба менежментийн захидлаар хөрөнгө бэлтгэх үйл ажиллагаа, авлага, өр

төлбөр, орлоготой холбоотой 3 зөвлөмж мэдэшдэл авсан байна. Зөвлөмжийн биелэлтийг 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 01/359 тоот албан бичгээр Булган аймгийн төрийн аудитын байгууллагад хүргүүлсэн байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Булган Мээж ХХК-ий 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Булган Мээж ХХК-ий 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

Бэлтгэсэн:

Аудитор

Д.Мягмарсүрэн

Огноо

Анхан шатанд хянасан:

Аудитын менежер

Ж.Энхцоодол

Огноо

Хоёр дахь шатанд хянасан:

Дарга, тэргүүлэх аудитор

Д.Анхбаяр

Огноо

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. НББ бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

НББ-ийн бодлогын баримт бичиг "Үндсэн хөрөнгийн бүртгэлийн бодлого"-д элэгдэл тооцох хугацааны зөрүү гаргахаар бол компани хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн дүнг тооцож бүртгэнэ гэж заасан боловч бүртгэдэггүй байна. Энэ нь НББОУС-12 "Орлогын албан татвар", Сангийн сайдын 2010 оны 121 дүгээр тушаалын хавсралт "Татварын өмнөх ашгаас татвар ногдуулах орлогыг тодорхойлох, үүсэх зөрүүг зохицуулах, нягтлан бодох бүртгэлд бүртгэх аргачлал" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Хойшлогдсон татварын өр төлбөр тооцоолохгүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрч бүртгэх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хойшлогдсон татварын өр төлбөрийг огт тооцдоггүй.

2. Авлага, өр төлбөртэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлангийн хугацааны эцэст нийт 609.3 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.5-д "Ерөнхий нягтлан бодогч хуульд заасан үүргийнхээ дагуу дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулж байх бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулж байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл:

Авлага барагдахгүй, холбогдох эзэнгүй найдваргүй болох.

2.3. Өгсөн зөвлөмж:

Харилцагч байгууллага болон хувь хүнтэй авлага, өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулж байх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цөөхөн тооцоо нийлээгүй газар байгаа эзэд нь Улаанбаатар хотод байдаг газар тайлангийн хугацаанд үүсээд он гарангуут барагдсан байгаа.

3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

2019 оны 6.7 сард худалдан авсан 8,460.0 мянган төгрөгийн цахилгаан үүсгэвэрийг үндсэн хөрөнгөнд бүртгэхдээ нэмэгдсэн өртгийн албан татвар хасаж бүртгэсэн. Азийн хөгжлийн банкны МОН 1907 төслөөр хийгдсэн Орон нутгийн нийтийн аж ахуйг сайжруулах зорилгоор хийгдсэн ажлын төлбөр өглөгөөр балансад бүртгэгдэн олон жил болсон байгаа нь НӨАТ -ын тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.1.5-д "Үндсэн хөрөнгө бэлтгэхэд зориулж импортоор оруулсан буюу худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн болон үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн албан татварыг хасахгүй" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл:

Үндсэн хөрөнгийг бага дүнгээр бүртгэлд тусгах.

3.3. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгахдаа төлсөн албан татварыг хасахгүй тусгах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Оны эцэст хуулийн заалтыг олж уншсан.

4. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө нөхсөн тэг үлдэгдэлтэй ашиглагдахгүй байгаа болон ашиглагдаж байгаа хөрөнгүүд бүртгэлтэй байгаа нь УСНББОУС үндсэн хөрөнгө 17-ийн 49 "Дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээс материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай" гэсэн заалттай нийцэхгүй байна.

4.2. Эрсдэл:

Үлдэгдэл өртөггүй хөрөнгө бүртгэлд удаан хугацаагаар тайлагнагдах.

4.3. Өгсөн зөвлөмж:

Дахин үнэлгээ хийх шийдвэрийг гаргуулан дахин үнэлгээг хийлгэн санхүүгийн тайланд тусгаж байх. Мөн тэг үлдэгдэлтэй ашиглагдахгүй байгаа хөрөнгийг заавар журмын дагуу актлуулах саналыг гаргуулан актлаж устгах.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Үндсэн хөрөнгийн дансанд тийм хөрөнгө их байдаг.

5. Бараа материал данстай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Няравын тайланд бараа материал худалдан авсан болон зарлагадсан зарим гүйлгээний анхан шатны баримтын иж бүрдэл дутуу, шаардах хуудас, орлого, зарлагын баримт гарын үсэг, тамга дутуу байна. Мөн худалдан авалтын анхан шатны баримтын цахим хэлбэрийн бүрдүүлэлт хангалтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно" 13.7-д "Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

5.2. Эрсдэл:

Бараа материал эзэн холбогдогчгүй дутагдах.

5.3. Өгсөн зөвлөмж:

Бараа материалын худалдан авалт болон зарцуулалттай холбоотой анхан шатны баримтын иж бүрдэлийг хангаж тайланд тусгах.

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Гарын үсэг дутуу няравууд баримтаа дутуу бүрдүүлж байна.

6. Бараа материалын данстай холбоотой асуудал

6.1. Илрүүлэлт:

2019 оны жилийн эцсээр бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогыг хийж баталгаажуулан тооцоог бодсон боловч аудитын биет тооллогоор бараа материалын дансанд бүртгэлтэй ном нэр төрөл, үнийн дүн зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

6.2. Эрсдэл:

Хөрөнгө дутагдах.

6.3. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг бүрэн хийж бүртгэлд тусгах.

6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Тайлбар хийгээгүй.

7. Бараа материалын данстай холбоотой асуудал

7.1. Илрүүлэлт:

Тус компани нь 2019 онд 653.4 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж өмнөх оноос алдагдал 696.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

7.2. Эрсдэл:

Эдийн засгийн үр өгөөж алдагдах.

7.3. Өгсөн зөвлөмж:

Дулаан цахилгаан станц ашиглалтанд орсонтой холбогдуулан компаний бүтэц, орон тоог шинэчлэн батлуулж, алдагдлыг бууруулах, ашигтай ажиллах эдийн засаг, үр ашиг, өртөг, зардлын тооцоо хийж ажиллах.

7.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид алдагдлыг бууруулах, бүтэц орон тоог шинэчилэх санал болосруулж шийдвэр гаргуулж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Д.МЯГМАРСҮРЭН

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.01	Мөнгөн хөрөнгө	839,229,525.27	590,211,833.70
1.3	Нийт хөрөнгө	7,539,630,531.13	7,962,064,193.65
2.4	Өр төлбөр эзний өмч	7,539,630,531.13	7,962,064,193.65

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
01	Борлуулалтын орлого	4,220,338,865.67	4,183,748,020.72
02	Борлуулалтын өртөг	3,623,302,043.33	4,394,521,516.34

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	4,501,476,715.39	4,663,744,196.26
1.2	Мөнгөн зарлагын дүн	4,326,431,562.56	4,865,839,250.78

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмч	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018.12.31	2,836,836,647.37	296,361,631.20	754,128,701.45	3,880,899,080.02
2019.12.31	3,986,864,869.67	296,361,631.20	94,320,571.23	4,377,547,072.10